

**АЖ АХУЙН НЭГЖИЙН ОРЛОГЫН АЛБАН ТАТВАРЫН ТУХАЙ ХУУЛЬД  
НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ХЭЛЭЛЦЭХ ЭСЭХ  
ТАЛААРХ ТӨСВИЙН БАЙНГЫН ХОРООНЫ САНАЛ, ДҮГНЭЛТ**

2023 оны 06 дугаар  
сарын 06-ны өдөр

Улаанбаатар  
хот

**Илтгэгч нь: Улсын Их Хурлын гишүүн Ж.Батсуурь**

Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газраас 2023 оны 06 дугаар сарын 02-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн хэлэлцэх эсэх хэлэлцүүлгийг Төсвийн байнгын хороо 2023 оны 06 дугаар сарын 06-ны өдрийн хуралдаанаараа хэлэлцлээ.

Төсөл санаачлагч эрчим хүчний тоног төхөөрөмж үйлдвэрлэгч дотоодын компаниудыг дэмжих, импортыг орлох эрчим хүчний үндсэн болон туслах тоног төхөөрөмжийг дотооддоо үйлдвэрлэх боломжийг бүрдүүлэх эрх зүйн орчныг шинээр бий болгох зайлшгүй шаардлагын үүднээс цахилгаан эрчим хүчний 5 мегаватаас дээш хүчин чадалтай, дулааны эрчим хүчний 1.5 мегаватаас дээш хүчин чадалтай эх үүсвэрийн үндсэн болон туслах тоног төхөөрөмж үйлдвэрлэх үндсэн үйл ажиллагааны орлогод ногдох албан татварыг 90 хувь хөнгөлөх нь зүйтэй гэж үзэж, Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулсан байна.

Байнгын хорооны хуралдаанаар хуулийн төслийг хэлэлцэх үед Улсын Их Хурлын гишүүн Д.Өнөрболор дулааны эх үүсвэрийн 1.5 мегаватаас дээш хүчин чадалтай эх үүсвэрт уурын зуух хамаарах эсэх, эрчим хүч үйлдвэрлэх, дамжуулах, түгээх, хангах үйл ажиллагааны зардлыг нөхөх замаар зах зээлийн өрсөлдөөний зарчимд шилжих боломжтой эсэх, мөн эрчим хүчний салбарт нэвтрүүлэх шинэ технологийн талаар, Улсын Их Хурлын гишүүн Ц.Сандаг-Очир татварын хөнгөлөлт, чөлөөлөлт үзүүлснээр үүсэх эдийн засгийн тооцооллын талаар, Улсын Их Хурлын гишүүн Б.Пүрэвдорж хуулийн төсөлд барааг тодорхойлох, кодлох уялдуулсан системийн кодыг тодорхой тусгах боломжтой эсэх талаар асуулт асууж, хариулт авсан.

Улсын Их Хурлын гишүүн Д.Өнөрболор энэ хуулийн зохицуулалтаар зөвхөн төрийн өмчит компанийг биш улсын хэмжээнд үйл ажиллагаа явуулж буй 1.5 мегаватаас дээш дулааны үндсэн эрчим хүчийг үйлдвэрлэж байгаа нүүрсээр ажиллах бүх станцуудыг татварын хөнгөлөлтөд хамруулахаар тусгасан нь уур амьсгалын өөрчлөлтийн эсрэг агаарын бохирдлыг бууруулах бодлоготой зөрчилдөх эрсдэлтэй учраас дэмжих боломжгүй гэсэн саналыг хэлсэн болно.

Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн олонх буюу 58.3 хувь нь дэмжиж, чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх нь зүйтэй гэж үзлээ.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн хэлэлцэх эсэх талаарх Төсвийн байнгын хорооны санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг Та бүхнээс хүсье.

Анхаарал тавьсанд баярлалаа.

ТӨСВИЙН БАЙНГЫН  
ХОРООНЫ ДАРГА



Г.ТЭМҮҮЛЭН